



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/18

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,
сунгах, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2.6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг нэгдүгээр, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл шинээр олгосон байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Жоншит” ХХК-ийн “Болор” нүдний үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож “Болор ундарга мэлмий” ХХК-д “Болор” нүдний үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг олгосугай.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /О.Энх-Уянга/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Д.Наранмичид/-д үүрэг болгосугай.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОМИССЫН
ДАРГА *Х.Доржханд* Х.ДОРЖХАНД



Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны 07 дугаар сарын
04 өдрийн 418 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрс**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Хэрлэн сумын Эмийн увидас” ХХК-ийн “Эрдэнэ тун” эмийн сан	3 жил	2023.07.26- 2026.07.26
2	Хэрлэн сумын “Мөнхийн тунсаг” ХХК-ийн дотор, хор судлалын үүдэн эмнэлэг	3 жил	2023.07.04- 2026.07.04
3	Өмнөдэлгэр сумын “Од мандах гэгээ” ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.07.04- 2026.07.04
4	Хэрлэн сумын “Зүүн салхит” ХХК-ийн “Аргабилэг” БЗДХ-ын үүдэн эмнэлэг	5 жил	2023.07.06- 2028.07.06

Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны 07 дугаар сарын
04 өдрийн 4/18 тоот тушаалын хоёрдугаар
хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл шинээр олгосон байгууллагын нэрс**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Зөвшөөрөл олгосон хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Хэрлэн сумын "Хан түшиг хайрхан" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.07.04-2026.07.04
2	Дадал сумын "Жаргалын хоймор" ХХК-ийн "Энхэрхэн үрс" хүүхдийн үүдэн эмнэлэг	3 жил	2023.07.04-2026.07.04
3	Баян-Адарга сумын "Дуурлиг хатан заяа" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.07.04-2026.07.04